



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Статистикийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/042/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Өлзийхишиг Утас: 325093 Цахим хаяг: ulziikhishigm@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
<u>Зөрчил арилгуулах тухай</u>	15
<u>Зөрчил арилгуулах тухай</u>	16
<u>Зөрчил арилгуулах тухай</u>	17

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХАОСЗТ	Хүн ам, орон сууцны завсрын тооллого
ӨНЭЗС	Өрх нийгэм, эдийн засгийн судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НЗДНХ	Нийслэлийн засаг даргын нөөц хөрөнгө

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-04-25 № 179

танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГА
Х.ОТГОНЗУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн статистикийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд хүн ам орон сууцны завсрын тооллого, нөөц ашиглалт, салбар хоорондын тэнцлийн судалгаа, дотоодын аялал жуулчлалын зардлын түүвэр судалгаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа гэх мэт томоохон судалгаанууд хийсэн байна

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд ҮСХ-ноос 10.5 сая төгрөгний компьютер тоног төхөөрөмж, нийслэлийн ЗДТГ-аас 33.4 сая төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

1476950271

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 43 арга хэмжээг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>49,686,639.64</u>	<u>51,282,308.20</u>
33	АВЛАГА	400,008.94	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	400,008.94	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,286,630.70	51,282,308.20
354	Хангамжийн материал	49,286,630.70	51,282,308.20
35410	Бичиг хэргийн материал	17,522,452.00	20,469,390.50
35420	Аж ахуйн материал	4,625,155.40	2,754,003.40
35440	Түлш, шатах тослох материал	3,975,000.00	1,595,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,164,023.30	26,463,914.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>208,196,213.50</u>	<u>162,758,217.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	208,196,213.50	162,758,217.56
392	Биет хөрөнгө	208,196,213.50	162,758,217.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	559,615,753.80	570,155,753.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(381,501,444.16)	(488,706,224.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,934,864.06	108,889,884.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,852,960.20)	(27,581,195.56)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>257,882,853.14</u>	<u>214,040,525.76</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>128,989.00</u>	<u>7,172,110.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	128,989.00	7,172,110.00
413	Өглөг	128,989.00	7,172,110.00
4136	Бусад өглөг	128,989.00	7,172,110.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	128989.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>257,753,864.14</u>	<u>206,868,415.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	257,753,864.14	206,868,415.76
512	Хуримтлагдсан үр дүн	257,753,864.14	206,868,415.76
51210	Өмнөх үеийн үр дүн	345,043,411.46	257,753,864.14
51220	Тайлант үеийн үр дүн	(87,289,547.32)	(50,885,448.38)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>257,882,853.14</u>	<u>214,040,525.76</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,881,015,627.66	4,107,434,792.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,725,239.16	47,240,020.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,725,239.16	47,240,020.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	23,450,269.16	46,895,020.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	222,470.00	345,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,857,290,388.50	4,060,194,772.75
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,151,657,900.00	2,526,837,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,151,657,900.00	2,526,837,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	705,632,488.50	1,533,357,072.75
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,516,000.00	326,235,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	631,116,488.50	1,207,121,372.75
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,968,305,174.98	4,158,320,241.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,968,305,174.98	4,158,320,241.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,783,364,640.90	4,039,196,196.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,248,138,099.07	2,811,299,824.30
210101	Үндсэн цалин	989,395,730.82	1,071,678,564.14
210102	Нэмэгдэл	347,968,635.32	355,333,477.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	234,552,000.00	400,085,000.00
210104	Урамшуулал	132,890,000.00	145,656,664.59
210105	Гэрээт ажлын хөлс	543,331,732.93	838,546,118.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,586,796.85	347,889,350.87
210201	Тэтгэврийн даатгал	193,695,446.09	244,890,380.19
210202	Тэтгэмжийн даатгал	22,679,901.46	28,733,859.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,141,626.95	10,340,758.26
210204	Ажилгүйдлийн даатгал	8,961,364.74	9,739,039.68
210205	Эрүүл мэндийн даатгал	44,108,457.61	54,185,312.87

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	674,145.00
210302	Түлш, халаалт	-	674,145.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,444,042.56	379,397,900.65
210401	Бичиг хэрэг	15,257,683.00	45,337,480.55
210402	Тээвэр, шатахуун	19,257,000.00	289,545,170.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,143,859.56	32,269,539.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,785,500.00	1,765,900.00
210408	Бараа материал акталсны зардал	-	10,479,811.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	6,490,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	6,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,159,044.00	348,457,409.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,706,544.00	344,244,209.31
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,452,500.00	4,213,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,725,582.42	144,987,565.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,256,855.00	6,274,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	21,780,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,468,727.42	116,933,015.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	184,940,534.08	119,124,045.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,581,059.00	2,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,905,000.00	2,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,359,475.08	117,024,045.06
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	125,359,475.08	117,024,045.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(87,289,547.32)</u>	<u>(50,885,448.38)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(87,289,547.32)</u>	<u>(50,885,448.38)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,857,342,888.50</u>	<u>4,060,194,772.75</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	52,500.00	-
120009	Бусад орлого	52,500.00	-

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,857,290,388.50	4,060,194,772.75
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,151,657,900.00	2,526,837,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,151,657,900.00	2,526,837,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	705,632,488.50	1,533,357,072.75
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,516,000.00	326,235,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	631,116,488.50	1,207,121,372.75
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,857,342,888.50</u>	<u>4,060,194,772.75</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,857,342,888.50	4,060,194,772.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,672,402,354.42	3,941,070,727.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,704,924,488.50	2,556,909,936.80
210101	Үндсэн цалин	897,364,638.91	1,048,277,213.98
210102	Нэмэгдэл	440,700,912.25	379,436,983.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	234,818,587.84	400,084,999.80
210104	Урамшуулал	129,925,204.50	144,442,324.69
210105	Гэрээт ажлын хөлс	2,115,145.00	584,668,415.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,586,796.85	347,889,350.87
210201	Тэтгэврийн даатгал	193,660,323.03	244,890,380.19
210202	Тэтгэмжийн даатгал	22,659,041.52	28,733,859.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,141,339.17	10,340,758.26
210204	Ажилгүйдлийн даатгал	8,953,398.08	9,739,039.68
210205	Эрүүл мэндийн даатгал	44,172,695.05	54,185,312.87
2104	Хангамж, бараа материалын зардал	72,628,318.56	376,383,813.15
210401	Бичиг хэрэг	10,435,960.00	47,139,419.05
210402	Тээвэр, шатахуун	20,365,000.00	284,056,205.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,393,859.56	32,269,539.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,433,499.00	12,918,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,771,076.00	20,880,000.00
210604	Урсгал засвар	11,771,076.00	20,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	6,490,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	6,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	603,951,674.51	602,796,276.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	601,499,174.51	598,583,076.87

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,452,500.00	4,213,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	184,940,534.08	119,124,045.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,581,059.00	2,100,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,676,059.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,905,000.00	2,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,359,475.08	117,024,045.06
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	125,359,475.08	117,024,045.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

						<i>/төгрөгөөр/</i>	
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	345,043,411.76	0.00	345,043,411.76	
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-0.30	0.00	-0.30	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	345,043,411.46	0.00	345,043,411.46	
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00	
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00	
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-87,289,547.32	0.00	-87,289,547.32	
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	257,753,864.14	0.00	257,753,864.14	
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	257,753,864.14	0.00	257,753,864.14	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	257,753,864.14	0.00	257,753,864.14	
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00	
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00	
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00	
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00	
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-50,885,448.38	0.00	-50,885,448.38	
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	206,868,415.76	0.00	206,868,415.76	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,567,886,300.00	2,526,837,700.00	41,048,600.00	98.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,567,886,300.00	2,526,837,700.00	41,048,600.00	98.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,562,981,300.00	2,407,713,654.94	155,267,645.06	93.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,051,261,700.00	1,972,241,521.65	79,020,178.35	96.15
210101	Үндсэн цалин	1,059,534,200.00	1,048,277,213.98	11,256,986.02	98.94
210102	Нэмэгдэл	404,652,400.00	379,436,983.18	25,215,416.82	93.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	402,879,400.00	400,084,999.80	2,794,400.20	99.31
210104	Урамшуулал	184,195,700.00	144,442,324.69	39,753,375.31	78.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	256,407,600.00	249,623,932.04	6,783,667.96	97.35
210201	Тэтгэврийн даатгал	174,357,200.00	171,656,704.00	2,700,496.00	98.45
210202	Тэтгэмжийн даатгал	20,512,600.00	20,194,906.42	317,693.58	98.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,256,300.00	9,848,181.77	408,118.23	96.02
210204	Ажилгүйдлийн даатгал	10,256,300.00	9,618,318.56	637,981.44	93.78
210205	Эрүүл мэндийн даатгал	41,025,200.00	38,305,821.29	2,719,378.71	93.37
2104	Хангамж, бараа материалын зардал	60,153,000.00	47,665,129.10	12,487,870.90	79.24
210401	Бичиг хэрэг	14,500,000.00	13,892,135.05	607,864.95	95.81
210402	Тээвэр, шатахуун	12,943,000.00	8,526,705.00	4,416,295.00	65.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,500,000.00	13,577,639.05	2,922,360.95	82.29
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,210,000.00	11,668,650.00	4,541,350.00	71.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,600,000.00	20,880,000.00	3,720,000.00	84.88
210604	Урсгал засвар	24,600,000.00	20,880,000.00	3,720,000.00	84.88

2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	-	1,700,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	-	1,700,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,738,800.00	102,821,722.15	38,917,077.85	72.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,723,800.00	98,608,522.15	37,115,277.85	72.65
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,015,000.00	4,213,200.00	1,801,800.00	70.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,120,200.00	14,481,350.00	12,638,850.00	53.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,120,200.00	7,501,350.00	6,618,850.00	53.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,000,000.00	6,980,000.00	6,020,000.00	53.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,905,000.00	119,124,045.06	(114,219,045.06)	2,428.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,905,000.00	2,100,000.00	2,805,000.00	42.81
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,905,000.00	2,100,000.00	2,805,000.00	42.81
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	117,024,045.06	(117,024,045.06)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	117,024,045.06	(117,024,045.06)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,533,357,072.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,533,357,072.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,533,357,072.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	584,668,415.15
210105	Гэрээт ажлын хөлс	584,668,415.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,265,418.83
210201	Тэтгэврийн даатгал	73,233,676.19
210202	Тэтгэмжийн даатгал	8,538,953.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	492,576.49

210204	Ажилгүйдлийн даатгал	120,721.12
210205	Эрүүл мэндийн даатгал	15,879,491.58
2104	Хангамж, бараа материалын зардал	328,718,684.05
210401	Бичиг хэрэг	33,247,284.00
210402	Тээвэр, шатахуун	275,529,500.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,691,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,490,000.00
210702	Дотоод албан томилолт	6,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	499,974,554.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	499,974,554.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,240,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	440,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,533,357,072.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,533,357,072.75
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	326,235,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,207,121,372.75

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Нийслэлийн авто баазтай гэрээ хийж суудлын авомашинаар хийсэн ажил нотлогдохгүй байна.	1	8,526.7			1	8,526.7							
Тогтмол зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил дансандаа бүртгэсэн байна	1	5,227.5					1	5,227.5					
Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлаас түүвэрлэн үзэхэд замын хуудас нь тайлангүй, зарцуулалт дээр нь хяналт хэрэгжүүлээгүй байна	1	5,872.4			1	5,872.4							
Дүн	3	19,626.6			2	14,399.1	1	5,227.5					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Хүн ам, орон сууцны завсарын тооллогын суурь мэдээллийн үнэн зөв, бодит байдал, чанарыг үнэлж дүгнэж сайжруулж шаардлагатай арга хэмжээний тайлан боловсруулах ажлыг үйл ажиллагааны чиглэл өөр аж ахуйн нэгжээр ажил гүйцэтгүүлж төлбөр төлсөн.	1	133,100.0			1	133,100.0						
Дүн	1	133,100.0			1	133,100.0						



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 58/ АУТЗ 1554

Улаанбаатар хот

НТАГ-2026/042/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн статистикийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Статистикийн тооллогоор автомашин гэрээлэн авсан үйлчилгээг шалгахад замын хуудас нь тайлангүй, зарцуулалтад хяналт тавихгүйгээр 6,276,753.90 (Зургаан сая хоёр зуун далан зургаан мянга долоон зуун тавин гурван төгрөг ерөн мөнгийг) зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн," заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн статистикийн газрын дарга (Х.Отгонзул), нягтлан бодогч (Д.Азжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

М.ӨЛЗИЙХИШИГ

1428990156



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 60/АУ271354

Улаанбаатар хот

НТАГ-2026/042/НН-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн статистикийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн авто баазтай гэрээ хийж суудлын автомашинаар үйлчлүүлсэн 8,526,705.00 (найман сая таван зуун хорин зургаан мянга долоон зуун таван) төгрөгний зардал нь төсвийг үр ашиггүй, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.", 6.3-д "энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Төсвийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн статистикийн газрын дарга (Х.Отгонзул), нягтлан бодогч (Д.Азжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

М.ӨЛЗИЙХИШИГ

1428990193



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 59/10271554

Улаанбаатар хот

НТАГ-2026/042/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн статистикийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл өөр аж ахуйн нэгжүүдээр нийт 133,100,000.00 (нэг зуун гучин гурван сая нэг зуун мянга) төгрөгийн тайлан, мэдээлэл боловсруулах ажил гүйцэтгүүлж төлбөрийг төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг ..., зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.; 5.1.4. үнэн зөв байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээт ажлыг үйл ажиллагааны чиглэлийн бус аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн статистикийн газрын дарга (Х.Отгонзул), нягтлан бодогч (Д.Азжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

М.ӨЛЗИЙХИШИГ

1428090191